

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН

“Дархан юнайтед арена” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн
тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/16/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Дархан-Уул аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:
Утас: 70378845
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер: У.Батсүрэн
Утас: 70373089
Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 70373089
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Сувдмаа
Утас: 70373089
Цахим хаяг: suvdmaakh@audit.gov.mn

Аудитор: **Д.Ариунзаяа**
Цахим хаяг: Ariunzayad@audit.gov.mn
Утас: 70373089

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.10 № НО
танай _____-ны № _____-т

“ДАРХАН ЮНАЙТЕД АРЕНА” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ С.ОДБААТАР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дархан юнайтед арена” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 273,285.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Хөдөлмөрийн гэрээнд үндсэн цалингийн хэмжээг захирлын тушаалаас 300.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, ажиллаагүй 4 хоногийн цалинд 245.5 мянган төгрөг тооцсон зэргээс шалтгаалж, нийт 545.5 мянган төгрөгийн цалин илүү олгосон,
- Байгууллагын захирал, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр зочин төлөөлөгч хүлээн авах зардалд 1,915.4 мянган төгрөгийн төлөвлөөгүй зардлыг санхүүжүүлсэн,
- Тайлант онд байгууллагын хөрөнгөөр төлөвлөгөөнд тусгагдаагүй архи, согтууруулах ундаа худалдан авахад зориулж 14,418.8 мянган төгрөг зарцуулсан,
- Менежментийн багийн 3 ажилтны орон сууцны түрээсийн төлбөрт 22,500.0 мянган төгрөг олгосон,

4526050285

- Урьдчилан тооцоо нийлж, өр төлбөрийг тооцоогүйгээс 229,612.3 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн,
- Худалдан авч, зарцуулсан 4,293.5 мянган төгрөгийн шатахууныг бараа материалын дансаар дамжуулалгүй үйл ажиллагааны зардалд бүртгэж, тайлагнасан байна.

Эдгээр зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.3, 20.1.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 9 дүгээр зүйлийн 9.2.2, 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.3, 18 дугаар зүйлийн 18.1, 18.2, 18.3, 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6, "Дархан юнайтед арена" ОНӨААТҮГ-ын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4, 8 дугаар зүйлийн 8.4-т заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус байгууллага нь тайлант онд үүссэн 229,612.3 мянган төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна. Үүнд: нэмэгдсэн өртгийн албан татварын 36,756.1 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварын 17,459.6 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн 35,871.7 мянган төгрөг, ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд цалингийн 9,513.5 мянган төгрөгийн өглөг, 62,917.6 мянган төгрөгийн урьдчилж орсон орлого байна. Мөн "Чандмана сонор" ХХК-д 12,373.7 мянган төгрөгийн, "Ган спорт менежмент" ХХК-д 54,700.0 мянган төгрөгийн өглөгийг гэрээнд заасан хугацаанд тус тус барагдуулаагүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд 3 нягтлан бодогч солигдсон бөгөөд нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үйл ажиллагааг менежментийн багийн зөвлөх үйлчилгээний менежер нь хариуцан ажиллаж байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга, "Дархан юнайтед арена" ОНӨААТҮГ-ын захиралтай 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр ОНБХГ/11 тоот "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г 1 жилийн хугацаатай байгуулсан тул гэрээ дүгнэх хугацаа болоогүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Мөрний дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
2	Эргэлтийн хөрөнгө	-	-
3	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	4,972,691.29
7	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
8	Бараа материал	-	109,841,351.22
9	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	700,000.00
10	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө(борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
12	Эргэлтийн хөрөнгийн дүн	-	115,514,042.51
13	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
14	Үндсэн хөрөнгө барилга	-	2,381,432,130.68
15	Биологийн хөрөнгө	-	-
20	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
21	Биет бус хөрөнгө	-	3,545,454.55
22	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	2,384,977,585.23
23	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	-	2,500,491,627.74
24	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
25	Өр төлбөр	-	-
26	Богино хугацаат өр төлбөр	-	-
27	Дансны өглөг	-	-
28	Цалингийн өглөг	-	9,513,507.99
29	Татварын өр	-	54,235,740.73
30	НДШ-ийн өглөг	-	35,871,681.64
34	Урьдчилж орсон орлого	-	62,917,605.05
35	Нөөц(өр төлбөр)	-	-
36	Бусад богино хугацаат өр төлбөр	-	67,073,751.71
37	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөд хамаарах өр	-	-
38	Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	229,612,287.12
45	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
46	Өр төлбөрийн нийт дүн	-	229,612,287.12
55	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	-	2,518,311,761.67
56	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-	(247,432,421.05)
57	Эздийн өмчийн дүн	-	2,270,879,340.62
58	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	-	2,500,491,627.74

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	853,340,900.33
2	Борлуулалтын өртөг	-	441,963.62
3	Нийт ашиг	-	852,898,936.71
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	40,142,234.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	119,000.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	-	1,139,937,691.76
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	416,900.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг алдагдал	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	(247,432,421.05)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татвар дараах ашиг (алдагдал)	-	(247,432,421.05)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(247,432,421.05)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
26	Бусад олз (гарз)	-	-
27	Орлогын нийт дүн	-	-
28	Нэгж хувьцааны ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2024 оны 01 сарын 01-ээр үлдэгдэл	-	-	-	-	-	-
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-
03	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-
06	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-
07	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-
09	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	-	-	-	-	-	-
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-	-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(247,432,421.05)	(247,432,421.05)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	2,518,311,761.67	-	2,518,311,761.67
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	-	-	-	2,518,311,761.67	(247,432,421.05)	2,270,879,340.62

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2	Мөнгөн орлогын дүн (+)	-	1,031,480,509.27
3	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	1,024,992,344.00
4	Эрхийн шимтгэл, хураамж төлбөрийн орлого	-	-
5	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
6	Буцаан авсан албан татвар	-	-
7	Татаас санхүүжилтийн орлого	-	-
8	Бусад мөнгөн орлого	-	6,488,165.27
9	Мөнгөн зарлагын дүн (-)	-	1,026,507,817.98
10	Ажиллагчдад төлсөн	-	329,613,397.88
11	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	44,673,488.67
12	Бараа материалын худалдан авахад төлсөн	-	575,997,682.93
13	Ашиглалтын зардалд төлсөн	-	-
14	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	-
15	Хүүний төлбөрт төлсөн	-	-
16	Татварын байгууллагад төлсөн	-	12,258,553.50
17	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
18	Бусад мөнгөн зарлага	-	63,964,695.00
19	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	4,972,691.29
20	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
21	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
22	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
23	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
52	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	4,972,691.29
53	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
54	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,972,691.29

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(Төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт	-	-	-	-	-
2	Нийт орлого	-	1,606,110,000.00	893,483,134.33	(712,626,865.67)	55.6
	Үүнээс: Цэвэр борлуулалт	-	1,588,610,000.00	853,340,900.33	(735,269,099.67)	53.7
	Бусад орлого	-	17,500,000.00	40,142,234.00	22,642,234.00	229.4
3	Нийт зардал	-	1,404,923,266.00	1,140,915,555.38	(264,007,710.62)	81.2
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-	441,963.62	441,963.62	0.0
	б) Ерөнхий удирдлагын зардал	-	1,404,923,266.00	1,140,473,591.76	(264,449,674.24)	81.2
	в) Үндсэн хөрөнгө данснаас хассан олз, гарз	-	-	-	-	-
4	Цэвэр ашиг, алдагдал	-	201,186,734.00	(247,432,421.05)	(448,619,155.05)	22.9

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн нийт 261,676.3 мянган төгрөгийн дараах 3 алдаа¹ илэрсэн нь НББОУС1 "Санхүүгийн тайлагналын толилуулга", санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хуваарилалт", "Толилуулга" зэрэг батламж мэдэгдлийг хангаагүй тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасны дагуу дараах байдлаар аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тус компани нь санхүүгийн байдлын тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 344.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг мөнгөн гүйлгээний тайлангийн мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлийг 344.4 мянган төгрөгөөр бууруулж,
2. Тайлант онд тооцоо нийлж, өр төлбөрийг баталгаажуулаагүйгээс санхүүгийн байдлын тайланд өр төлбөрийг 37,776.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг нийт өр төлбөрийн дүнг 37,776.9 мянган төгрөгөөр бууруулж,
3. Санхүүгийн байдлын тайланд эздийн өмчийг 223,555.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг бууруулж, санхүүгийн тайланд тус тус залруулав.

Мөн аудитаар нийт 273,285.5 мянган төгрөгийн зөрчил²-д 2,460.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 18,712.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 252,112.3 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд нярав Х.Мөнхзулын хөдөлмөрийн гэрээнд үндсэн цалингийн хэмжээг захирлын тушаалаас 300.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, ажиллаагүй 4 хоногийн цалинд 245.5 мянган төгрөг тооцсоноос нийт 545.5 мянган төгрөгийн цалин илүү олгож, байгууллагын хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох", "Дархан юнайтед арена" ОНӨААТҮГ-ын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4-т "Захирал нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана", 8 дугаар зүйлийн 8.4-т "Нягтлан бодогч хуулиар тогтоосон журмын дагуу анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах ажлыг хариуцан зохион байгуулж, захиралд танилцуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

2. Тус байгууллагын захирал, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр зочин төлөөлөгч хүлээн авах зардалд 1,915.4 мянган төгрөгийн төлөвлөөгүй зардлыг санхүүжүүлж, үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.7-д "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-д "Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", 20.1.3-д "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”, “Дархан юнайтед арена” ОНӨААТҮГ-ын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4-т “Захирал нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана”, 8 дугаар зүйлийн 8.4-т “Нягтлан бодогч хуулиар тогтоосон журмын дагуу анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах ажлыг хариуцан зохион байгуулж, захиралд танилцуулна” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

1. Тайлант онд байгууллагын хөрөнгөөр архи, согтууруулах ундаа худалдан авахад зориулж 14,418.8 мянган төгрөг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.7-д “Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах”, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6-д “Согтууруулах ундааг гар дээрээс, эсхүл согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлгүйгээр, эсхүл тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан, түдгэлзүүлсэн үед худалдах, түүгээр үйлчлэх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-д “Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах”, 20.1.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”, “Дархан юнайтед арена” ОНӨААТҮГ-ын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4-т “Захирал нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана”, 8 дугаар зүйлийн 8.4-т “Нягтлан бодогч хуулиар тогтоосон журмын дагуу анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах ажлыг хариуцан зохион байгуулж, захиралд танилцуулна” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн албан шаардлага хүргүүлэв.

2. Тус газар нь тайлант онд худалдан авч, зарцуулсан 4,293.5 төгрөгийн шатахууныг бараа материалын дансаар дамжуулалгүй үйл ажиллагааны зардалд бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна, 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3-т “Бүх өр төлбөр”, “Бараа материалыг НББОУС12 “Бараа материал”-ын дагуу бүртгэнэ”, 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.4-т “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.4.1 Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага нь тайлант онд урьдчилан тооцоо нийлж, өр төлбөрийг тооцоогүйгээс 229,612.3 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар

зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д "Хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д заасныг хэрэгжүүлэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө, хуваарь гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах

5.4.2 Нягтлан бодох бүртгэлийн бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага нь өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9."нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 20 дугаар зүйлийн 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.2-т заасныг хэрэгжүүлэн, өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллах

5.4.3 Орон сууцны түрээсийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд менежментийн багийн зөвлөх үйлчилгээний 3 ажилтанд орон сууцны түрээсийн төлбөр 22,500.0 мянган төгрөг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 14 дүгээр зүйлийн 14.3.1-т "анхан шатны баримт бүрдүүлэх", Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.2.6-т "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн дагуу анхан шатны бүртгэл хөтлөх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын баталсан маягт, аргачлалын дагуу зохих мэдээ, тайланг цаг тухайд нь гаргаж өгөх", ОНӨААТҮГ-ын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4-т "Захирал нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3.1, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.2.6, Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлж, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр зардлыг гаргах

5.4.4 Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 3 нягтлан бодогч солигдсон бөгөөд нягтлан бодох бүртгэл хөтлөх санхүүгийн тайлан гаргах үйл ажиллагааг менежментийн багийн зөвлөх үйлчилгээний менежер нь хариуцан ажиллаж байгаагаас санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн, бүртгэл тайлан хөтлөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, санхүүгийн тайланг гаргаж, тайлагнах этгээд нь мэргэжлийн, эсхүл мэргэшсэн нягтлан бодогч байна”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.1-т “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана”, 14.3.1-т “анхан шатны баримт бүрдүүлэх”, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.2.6-т “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн дагуу анхан шатны бүртгэл хөтлөх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын баталсан маягт, аргачлалын дагуу зохих мэдээ, тайланг цаг тухайд нь гаргаж өгөх”, ОНӨААТҮГ-ын дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4-т “Нягтлан бодогч хуулиар тогтоосон журмын дагуу анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах ажлыг хариуцан зохион байгуулж, захиралд танилцуулна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.3.1, 18 дугаар зүйлийн 18.3, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.2.6, Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлж, анхан шатны баримтад үндэслэн зардал гаргах, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 344.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	1	344.4			1	344.4	1	344.4	-	-	-	-
Санхүүгийн байдлын тайланд өр төлбөрийг 37,776.9 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	1	37,776.9			1	37,776.9	1	37,776.9				
Санхүүгийн байдлын тайланд эздийн өмчийг 223,555.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан	1	223,555.0			1	223,555.0	1	223,555.0				
Дүн	3	261,676.3			3	261,676.3	3	261,676.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант онд нярав Х.Мөнхзулын үндсэн цалинг баталсан төсвөөс 300.0 мянган төгрөгөөр үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн, 4 хоногийн 245.5 мянган төгрөгийн цалинг илүү тооцон олгож, байгууллагын хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.	1	545.5	1	545.5	-	-	-	-	-	-	-	-

Тус байгууллагын дарга эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр хоолны зардалд 1,915.4 мянган төгрөгийн төлөвлөгдөөгүй зардал гаргаж, хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна	1	1,915.4	-	1,915.4	-	-	-	-	-	-	-	-
Архи, согтууруулах ундаанд 14,418.8 мянган төгрөг зарцуулсан байна	1	14,418.8	-	-	1	14,418.8	-	-	-	-	-	-
Худалдан авч, зарцуулсан 4,293.5 мянган төгрөгийн шатахууныг бараа материалын дансаар дамжуулалгүй үйл ажиллагааны зардалд бүртгэж, тайлагнасан байна.	1	4,293.5	-	-	1	4,293.5	-	-	-	-	-	-
Тайлант онд урьдчилан тооцоо нийлж, өр төлбөрийг тооцоогүйгээс 229,612.3 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.	1	229,612.3	-	-	-	-	1	229,612.3	-	-	-	-
Тус байгууллага нь өөрийн байгууллагын онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Менежментийн багийн зөвлөх үйлчилгээний 3 ажилтанд орон сууцны түрээсийн төлбөр 22,500.0 мянган төгрөг олгосон	1	22,500.0	-	-	-	-	1	22,500.0	-	-	-	-
Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, бүртгэл тайлан хөтлөөгүй байна	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	8	273,285.5	2	2,460.9	2	18,712.3	4	252,112.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	/мянган төгрөгөөр/												
	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус байгууллага нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 427,248.3 мянган төгрөгийн 35 гүйлгээг хугацаа	1	911,427.6	-	-	-	-	-	1	911,427.6	-	-	-	-

хоцроож, 253,277.0 мянган төгрөгийн 15 гүйлгээ, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 230,902.3 мянган төгрөгийн мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.													
Дүн	1	911,427.6	-	-	-	-	1	911,427.6	-	-	-	-	